



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/252/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХҮЕГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХАОНӨГ	Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/85
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭХУЯГ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	96,513,706.03	89,673,098.03
34	УРЬДЧИЛГАА	2,100,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,100,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	94,413,706.03	89,673,098.03
351	Түүхий эд материал	119,300.00	00.00
35130	Эм боох материал	119,300.00	00.00
354	Хангамжийн материал	94,294,406.03	89,673,098.03
35420	Аж ахуйн материал	27,276,350.03	24,379,410.03
35440	Түлш, шатах тослох материал	20,138,000.00	12,749,888.00
35460	Хүнсний материал	1,507,556.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	45,372,500.00	52,543,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,491,350,660.74	1,521,271,609.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,491,350,660.74	1,521,271,609.09
392	Биет хөрөнгө	1,362,904,460.74	1,390,823,509.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,124,657,995.99	1,124,657,995.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-73,166,708.35	-107,358,591.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	256,447,875.00	188,049,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-213,416,543.89	-146,949,875.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	389,617,781.24	302,503,642.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-282,545,498.61	-122,892,400.20
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,945,323.59	111,073,240.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-85,138,558.79	-65,006,009.03
39214	Бусад үндсэн хөрөнгө	141,013,684.51	141,013,684.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,510,889.95	-34,268,052.83
393	Биет бус хөрөнгө	128,446,200.00	130,448,100.04
39301	Програм хангамж	9,801,900.00	9,801,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,301,900.00	-1,299,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	121,946,200.00	121,946,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,587,864,366.77	1,610,944,707.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,587,864,366.77	1,610,944,707.12
51	Засгийн газрын хувь оролцоо	1,587,864,366.77	1,610,944,707.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	121,946,200.00	121,946,200.00
51101	Өмч: - төрийн	121,946,200.00	121,946,200.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,391,283,623.12	1,414,363,963.47
51210	Өмнөх үеийн үр дүн	1,391,283,623.12	1,391,283,623.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	23,080,340.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,634,543.65	74,634,543.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,587,864,366.77	1,610,944,707.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,137,836,878.36	1,149,302,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	259,786,178.36	288,027,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	259,786,178.36	288,027,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	259,786,178.36	288,027,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,065,236.00	130,462,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,720,942.36	157,565,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	878,050,700.00	861,274,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	866,600,700.00	848,639,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	866,600,700.00	848,639,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,450,000.00	12,635,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,450,000.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	35,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,163,184,389.15	1,126,200,504.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,163,184,389.15	1,126,200,504.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,124,285,225.21	1,094,296,975.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	642,567,903.69	650,109,221.83
210101	Үндсэн цалин	499,204,926.00	504,298,112.83
210102	Нэмэгдэл	126,495,477.69	121,618,615.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,867,500.00	24,192,494.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,422,454.44	88,240,020.00
210201	Тэтгэврийн даатгал	57,508,633.03	62,095,774.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,636,784.31	6,755,225.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,140,543.22	5,263,059.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,135.81	1,284,180.23
210205	Эрүүл мэндийн даатгал	12,851,358.07	12,841,780.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,308,894.78	60,949,515.51
210301	Гэрэл, цахилгаан	10,294,785.78	7,602,448.23
210302	Түлш, халаалт	22,939,505.00	44,937,554.52
210303	Цэвэр, бохир ус	10,074,604.00	8,409,512.76
2104	Хангамж, бараа материалын зардал	48,990,721.30	35,469,653.56
210401	Бичиг хэрэг	5,810,600.00	7,211,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,746,955.00	11,352,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,169,671.32	2,597,818.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,117,700.00	1,130,400.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,585,270.00	7,226,045.00
210408	Бараа материал акталсны зардал	8,560,524.98	5,951,540.00
2105	Нормативт зардал	70,770,595.29	52,899,733.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	597,900.00	1,157,300.00
210502	Хоол, хүнс	69,890,250.29	51,532,433.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	282,445.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,787,050.00	2,773,000.00
210604	Урсгал засвар	1,787,050.00	2,773,000.00
2107	Томилолт, зочны зардал	185,500.00	146,000.00
210702	Дотоод албан томилолт	185,500.00	146,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	106,556,820.64	77,425,134.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,030,678.64	76,049,677.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	247,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,142.00	235,642.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	346,500.00
210807	Газрын төлбөр	1,400,000.00	458,115.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,695,285.07	126,284,696.89
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,695,285.07	126,284,696.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,899,163.94	31,903,529.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,657,491.00	16,180,846.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,393,491.00	15,229,654.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,264,000.00	951,192.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,241,892.94	14,722,133.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,241,892.94	14,722,133.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,999,780.00	1,000,550.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,999,780.00	1,000,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,347,510.79	23,101,995.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	21,654.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	21,654.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-21,654.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-25,347,510.79	23,080,340.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
С01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,346,200.00	1,499,741,937.08	1,697,722,680.73

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,346,200.00	1,499,741,937.08	1,697,722,680.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-78,237,026.17	-78,237,026.17
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,946,200.00	1,391,283,623.12	1,587,864,366.77
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,946,200.00	1,391,283,623.12	1,587,864,366.77
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,946,200.00	1,391,283,623.12	1,587,864,366.77
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	23,080,340.35	23,080,340.35
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,946,200.00	1,414,363,963.47	1,610,944,707.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,054,465,936.00	991,736,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	176,415,236.00	130,462,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	176,415,236.00	130,462,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	176,415,236.00	130,462,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,415,236.00	130,462,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	878,050,700.00	861,274,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	866,600,700.00	848,639,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	866,600,700.00	848,639,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,450,000.00	12,635,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	6,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,450,000.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	35,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,031,415,936.00	986,236,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,031,415,936.00	986,236,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,516,772.06	954,333,270.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	642,567,903.69	650,109,221.83
210101	Үндсэн цалин	499,204,926.00	504,298,112.83
210102	Нэмэгдэл	126,495,477.69	121,618,615.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,867,500.00	24,192,494.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,422,454.44	88,240,020.00
210201	Тэтгэврийн даатгал	57,508,633.02	62,035,869.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,636,784.31	6,681,613.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,140,543.23	5,258,030.84

210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,135.81	1,296,682.44
210205	Эрүүл мэндийн даатгал	12,851,358.07	12,967,823.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,426,894.78	53,621,403.51
210301	Гэрэл, цахилгаан	10,294,785.78	7,602,448.23
210302	Түлш, халаалт	37,057,505.00	37,609,442.52
210303	Цэвэр, бохир ус	10,074,604.00	8,409,512.76
2104	Хангамж, бараа материалын зардал	34,704,426.32	30,303,613.56
210401	Бичиг хэрэг	5,265,600.00	7,211,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,968,530.00	11,292,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,169,671.32	2,597,818.56
210404	Ном, хэвлэл	525,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,117,700.00	1,130,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,657,925.00	8,071,545.00
2105	Нормативт зардал	62,934,027.19	51,272,877.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	717,200.00	1,038,000.00
210502	Хоол, хүнс	61,934,382.19	50,024,877.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	282,445.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,251,550.00	5,315,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	464,500.00	2,542,000.00
210604	Урсгал засвар	1,787,050.00	2,773,000.00
2107	Томилолт, зочны зардал	185,500.00	146,000.00
210702	Дотоод албан томилолт	185,500.00	146,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,024,015.64	75,325,134.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,497,873.64	73,949,677.85
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	247,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,142.00	235,642.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	473,000.00	346,500.00
210807	Газрын төлбөр	1,400,000.00	458,115.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,899,163.94	31,903,529.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,657,491.00	16,180,846.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,393,491.00	15,229,654.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,264,000.00	951,192.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,241,672.94	15,722,683.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,241,892.94	14,722,133.25
213304	Хөрөнгийн	4,999,780.00	1,000,550.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,050,000.00	5,500,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,050,000.00	5,500,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,050,000.00	5,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,050,000.00	5,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,050,000.00	5,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-23,050,000.00	-5,500,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,205,599,800.0	964,379,666.8	241,220,133.3	80.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,599,800.0	964,379,666.8	241,220,133.3	80.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,188,337,700.0	948,198,820.8	240,138,879.3	79.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	650,719,900.0	650,109,221.8	610,678.2	99.9
210101	Үндсэн цалин	496,197,400.0	504,298,112.8	-8,100,712.8	101.6
210102	Нэмэгдэл	134,437,400.0	121,618,615.0	12,818,785.0	90.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,085,100.0	24,192,494.0	-4,107,394.0	120.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,767,200.0	88,240,020.0	1,527,180.0	98.3
210201	Тэтгэврийн даатгал	64,058,400.0	62,035,869.1	2,022,530.9	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	6,427,200.0	6,681,613.6	-254,413.6	104.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,141,800.0	5,258,030.8	-116,230.8	102.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,400.0	1,296,682.4	-11,282.4	100.9
210205	Эрүүл мэндийн даатгал	12,854,400.0	12,967,824.0	-113,424.0	100.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,376,200.0	53,621,403.5	754,796.5	98.6
210301	Гэрэл, цахилгаан	8,332,100.0	7,602,448.2	729,651.8	91.2
210302	Түлш, халаалт	37,610,300.0	37,609,442.5	857.5	100.0
210303	Цэвэр, бохир ус	8,433,800.0	8,409,512.8	24,287.2	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	32,294,600.0	22,669,163.6	9,625,436.4	70.2
210401	Бичиг хэрэг	3,729,300.0	3,255,250.0	474,050.0	87.3
210402	Тээвэр, шатахуун	9,921,100.0	8,114,150.0	1,806,950.0	81.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,877,800.0	2,097,818.6	1,779,981.4	54.1
210404	Ном, хэвлэл	430,400.0	00.0	430,400.0	00.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,861,700.0	1,130,400.0	1,731,300.0	39.5

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,474,300.0	8,071,545.0	3,402,755.0	70.3
2105	Нормативт зардал	126,786,600.0	51,272,877.0	75,513,723.0	40.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,200,000.0	1,038,000.0	162,000.0	86.5
210502	Хоол, хүнс	124,160,000.0	50,024,877.0	74,135,123.0	40.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,426,600.0	210,000.0	1,216,600.0	14.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,741,500.0	10,815,000.0	14,926,500.0	42.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,344,600.0	8,042,000.0	11,302,600.0	41.6
210604	Урсгал засвар	6,396,900.0	2,773,000.0	3,623,900.0	43.3
2107	Томилолт, зочны зардал	148,400.0	146,000.0	2,400.0	98.4
210702	Дотоод албан томилолт	148,400.0	146,000.0	2,400.0	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,503,300.0	71,325,134.9	137,178,165.2	34.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,281,200.0	69,949,677.9	136,331,522.2	33.9
210803	Даатгалын үйлчилгээ	680,000.0	247,200.0	432,800.0	36.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,000.0	235,642.0	100,358.0	70.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.0	88,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	568,100.0	346,500.0	221,600.0	61.0
210807	Газрын төлбөр	550,000.0	458,115.0	91,885.0	83.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,262,100.0	16,180,846.0	1,081,254.0	93.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,262,100.0	16,180,846.0	1,081,254.0	93.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,310,900.0	15,229,654.0	1,081,246.0	93.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	951,200.0	951,192.0	08.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,205,599,800.0	964,379,666.8	241,220,133.3	80.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	848,639,800.0	833,917,666.8	14,722,133.3	98.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	848,639,800.0	833,917,666.8	14,722,133.3	98.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	356,960,000.0	130,462,000.0	226,498,000.0	36.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	356,960,000.0	130,462,000.0	226,498,000.0	36.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	58.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	48.00	48.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00	00.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	58.00	58.00	00.0	100.0
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	47.00	47.00	00.0	100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	00.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,635,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,635,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,634,450.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,634,450.00
210401	Бичиг хэрэг	3,955,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,178,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,550.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,635,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,635,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага болох Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хууль тогтоомжтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтайбаяр, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих гэсэн зарчмыг баримтлан “Халамж хүртэгчээс Баялаг бүтээгч” гэсэн алсын хараагаар зорилгоо тодорхойлжээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, ажил идэвхтэй хайгч иргэнийг мэргэшүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх, чадваржуулах арга хэмжээг зохион байгуулах
- Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт орж ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 17.4 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 17.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.1 сая төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт 3=2-1
Б	1	2	3=2-1
Бараа материал	94.41	89.67	- 4.7
Биет хөрөнгө	1,362.90	1,390.82	27.9
Биет бус хөрөнгө	128.45	130.45	02.0
Нийт хөрөнгө	1,587.86	1,610.94	23.1
Хуримтлагдсан үр дүн	1,391.28	1,414.36	23.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,587.86	1,610.94	23.1

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.7 сая төгрөгөөр буурсан нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын даргын 2022.01.12 өдрийн А/01 тушаалаар акталсан 5.9 сая төгрөгийн бараа материалыг акталснаас шалтгаалжээ. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 27.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 2021 оны 3/917 тушаал, Сангийн сайдын 2021 оны А/09 тушаалаар эрх шилжин хэрэгжиж ахмадын байгууллагын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээнд “Санаа мэд трейд” ХХК-аас 22.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, “Хөвсгөл жугнай” ХХК-аас 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж эрх шилжүүлэн хүлээн авсан байна.
- Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 он А/95, А/395 тоот тушаалуудаар 7.7 сая төгрөгийн компьютер, техник хэрэгсэл зэрэг хөрөнгийг шинээр хүлээн авсан.
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111-р тогтоолоор дахин үнэлсэн 101.0 сая төгрөг, төсвийн хөрөнгөөр 5.5 сая төгрөгийн компьютер худалдан авсан байна

Биет бус хөрөнгийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 241.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан.
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 109 дүгээр тогтоолоор 87.7 сая төгрөгийн хөрөнгө акталсан байна.
Дээрх хөрөнгийн хугацааг сунгаж өртгийг шинэчлэн орлого авсантай холбоотойгоор биет бус хөрөнгө өссөн байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 1,414.4 сая төгрөг болж 23.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 37.0 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс хангамж, бараа материалын зардал 13.5 сая төгрөг буюу 27.6 хувь, норматив зардал 17.9 сая төгрөг буюу 25.3 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 29.1 сая төгрөг буюу 27.3 хувиар буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,213.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 1,205.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,205.6 сая төгрөгийн төсөв батлагдсаны 848.6 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 356.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 833.9 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 130.5 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч урсгал үйл ажиллагаанд 964.4 сая төгрөгийг зарцуулж, 14.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 964.4 сая төгрөг буюу 80.0 хувьтай байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь зардлыг санхүүжүүлэх 1 үүсвэр болох үйл ажиллагаанаас орох орлого 226.5 сая төгрөгөөр тасарсан нь ковид цар тахалтай холбоотой байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71902 Нийгмийн халамж

Зориулалт арга хэмжээ: 80101 -үндсэн үйл ажиллагаа
80103 -гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ
80802 -ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал

Хүснэгт 2. Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулав. /сая.төг/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
71902	Нийгмийн халамж	1,205.6	964.4	-241.2	-20
80101	Үндсэн үйл ажиллагаа	831.4	817.7	-13.6	-1.6
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	357.0	130.5	-226.5	-63.5
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	17.3	16.2	-1.08	-6.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн арга хэмжээний зардлын хүснэгт /сая.төг/

№	Орлого			Зарлага	Үлдэгдэл	Төвлөрүүлсэн
	Байгууллага	Зориулалт	Дүн			
1	ХХҮГ	Өрхийн судалгааны санхүүжилт	6.0	5.0	1.0	1.0
2	Герман улсын /GFA/ компани	Мөшгөх судалгааны санхүүжилт	6.6	6.60	-	-
3	ХАОНӨГ	Нэмэлт орлого	0.04	0.04	-	-
ДҮН			12.64	11.63	1.0	1.0

Тайлант онд Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газраас өрхийн судалгааны санхүүжилт 6.0 сая төгрөг, Герман улсын /GFA/ компаниас мөшгөх судалгааны санхүүжилт 6.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газраас 0.04 сая төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан байна.

Үүнээс өрхийн судалгааны зардалд 5.0 сая төгрөг, мөшгөх судалгаанд 6.6 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 0.35 сая төгрөгийг тус тус зарцуулж 1.0 сая төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас ахмадын амрагчдын тоо багасаж өөрийн орлого, үйлчилгээ хязгаарлагдмал байсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж нийт зардлыг 241.2 сая төгрөг буюу 20 хувийн хэмнэлт гаргасан явдал байна. Үүнд: материаллаг хэмжээтэй байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.7 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 9.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 137.1 сая төгрөг, норматив зардал 75.5 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Өөрийн орлогыг 356.9 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 130.4 сая төгрөг байгаа нь коронавирусын цар тахлын нөхцөл байдлын улмаас Улсын онцгой комисс, Засгийн газрын шийдвэрээр ахмад настны сувиллын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой байна.

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2021 онд 1,321.1 сая төгрөгийн 73 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,321.1 сая төгрөгийн 73 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн ба дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 0.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжөөс ХХҮЕГ нь төсвийн саналыг харгалзалгүйгээр бууруулан баталсан хэвээр байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн байдлыг анхаарч үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төрийн бус байгууллагаас худалдан авсан И-баримтгүй 0.8 сая төгрөгийн шингэрүүлсэн хийн түлшний гүйлгээ хийгдсэнийг завсрын аудитын явцад нөхөн бүрдүүлж бүртгэлд тусган тайлагнасан.
- Түлээ, нүүрс худалдан авахдаа тендерийн гэрээний үнийг баримтлахгүйгээр 0.02 мянган төгрөгийн нүүрс худалдан авсныг завсрын аудитын явцад залруулсан.
- Шатахуун зарцуулалтыг тогтоосон норм, нормативыг түүвэрлэн шалгахад 0.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал “автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норматив”-ын дагуу автомашины шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтаас түүвэрлэн үзэхэд 0.1 сая төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан байна. Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах гэж заасан жишиг нормативтай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын дагуу шатахуун зарцуулалтын жишиг нормыг мөрдөн, хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	3	0.9	2	0.8	-	-	-	-	1	0.1